



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

Г Иргэн Х.Ганхуягийн “Ремикон” ХК-д 7
оруулсан хөрөнгийг хувьцаанд хөрвүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 117 дугаар тогтоолын 4 дэх заалт, 2010 оны 237 дугаар тогтоолын 2 дахь заалт, “Ремикон” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2010 оны 07, 2011 оны 10/1 дугаар тогтоол, хувь нийлүүлэгчдийн 2011 оны ээлжит бус хурлын 05/4 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 117 дугаар тогтоолын 4 дэх заалтын дагуу “Ремикон” ХК-ийн үүсгэн байгуулагч Х.Ганхуягийн нэмж оруулах хөрөнгөд дүйцүүлэн хөрвүүлэхээр тусгаарлаад байсан 16 334 262 /арван зургаан сая гурван зуун гучин дөрвөн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дахь түүний дансанд байршуулж өмчлөх эрхийг баталгаажуулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

2. Х.Ганхуягийн компанид нийлүүлэх хөрөнгийн асуудал эцэслэн шийдэгдсэнтэй холбогдуулан Хорооны 2008 оны 117 дугаар тогтоолын 3 дахь заалтад заасан түүний нэр дээр тусгаарлаад байсан 11 857 000 /арван нэгэн сая найман зуун тавин долоон мянга/ ширхэг хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д даалгасугай.

3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан санхүүгийн тайлан, болон улсын бүртгэлийн гэрчилгээнд зохих өөрчлөлтийг хийж хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж ажиллахыг “Ремикон” ХК /Э.Мөнхсайхан/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/-г, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН